



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/299

Чингис хот

Усны аюулгүй байдлын төлөвлөгөө
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амыг аюулгүй цэвэр усаар хангах зорилгоор хэрэгжүүлж буй "Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах" ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч:	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Хэнтий Ус ХХК-ийн гүйцэтгэх захирал
Гишүүд:	Эрүүл мэндийн газрын дарга
	Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын дарга
	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
	Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга
	Сумдын Засаг дарга нар
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Хэрлэн голын сав газрын захиргааны дарга
	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны дарга
	Онон угалзын сав газрын захиргааны дарга
	Хэнтий Ус ХХК-ийн ашиглалтын инженер

2. Хэнтий аймгийн ус хангамжийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, ус хангамжийн системийн байршлын зураглал гарган, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг багаар ажиллахыг нарийн бичгийн дарга /Г.Батгэрэл/-д даалгасугай.

2.

3. Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулалт, үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА